# 7.2 Батлагдаагүй төлөвтэй суралцагч

### 7.2 Батлагдаагүй төлөвтэй суралцагч

Бүртгэж оруулсан суралцагч нь **суралцагч** модулийн суралцагчийн жагсаалтад **батлагдаагүй** төлөвтэй бүртгэгдэж орж ирнэ. Дараах зургаас харна уу.




**Анхаарах нь**: Суралцагчийг сургуульд системээр бүртгэн авсны дараа суралцагчийн жагсаалтад **батлагдсан эсэх** баганад **батлагдаагүй** төлөвтэй байгаа эсэхийг шалгана уу. Батлагдсан төлөвтэй болсны дараа суралцагчийг сургуульд бүрэн бүртгэж дууссан гэж үзнэ.

### Баталгаажуулах хүсэлт

Энэхүү үйлдлийг тухайн сургуульд суралцагч шилжиж ирэх, шинээр элсэн орох болон **батлагдаагүй** төлөвтэй байгаа суралцагчийг **батлагдсан** төлөвтэй болгох үед ашиглана.

1. Батлагдаагүй төлөвтэй суралцагчийг сонгож идэвхижүүлнэ. Нэр бүхий мөрний өнгө өөрчлөгдөнө.

2. **Үйлдэл** хэсгээс **Баталгаажуулах хүсэлт** үйлдлийг сонгоно.




**Суралцагч** цонхны суралцагчийн жагсаалтаас **Батлагдаагүй** төлөвтэй байгаа суралцагчийг сонгож цонхны баруун дээд хэсэгт байрлах  үйлдлийн арын сум дээр дарж **Баталгаажуулах хүсэлт** үйлдлийг хийхэд төлөв дараах байдлаар өөрчлөгдөнө.

| **Төлөв** | **Тайлбар** |
|---|---|
| **Батлагдсан** | Батлагдсан төлөв нь бүртгэгдэж баталгаажсан суралцагч юм. |
| **Хянагдаж байгаа** | Суралцагч нь 6-аас доош настай эсвэл суралцах түвшин зөрүүтэй ангид бүртгэл хийсэн тохиолдолд "Хянагдаж байгаа" төлөвт орно. |
| **Цуцлагдсан** | Бичиг баримт бүрэн бус эсвэл хөтөлбөр хооронд сольж бүртгэсэн гэх мэт шалтгаануудаас болж цуцлагдсан төлөвт орно. |